



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 1/58

Улаан-Уул

Сумын нутаг дэвсгэрт байрлах үл хөдлөх
эд хөрөнгийн хаягийн бүртгэл, судалгаа
хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт байрлах үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн бүртгэл, судалгааг хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Зоригт - Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Газрын даамал

Г.Эрдэнэсан- Татварын улсын байцаагч


Г.Нямдаваа- Улаан-Уул 6-р багийн засаг дарга

Нарийн бичгийн дарга: Ц.Эрдэнэчимэг -Улсын бүртгэгч

2. Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5283:2014 стандартыг баримтлан ажиллахыг ажлын хэсгийн хэсэгт, ажлын явц, гүйцэтгэлийн талаар хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Зоригт)-д тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ЭРДЭНЭБАТ

642201095